



МУХАУТ-ЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн 2015
оны 2 дугаар сарын 19 -ний өдрийн хурлын
..... тоот тогтоолоор батлав.

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

2016 ОН - ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ ЖИЛ

СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

- Стратегийн зорилго 1:** Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх
- Стратегийн зорилго 2:** Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах
- Стратегийн зорилго 3:** Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах
- Стратегийн зорилго 4:** Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх
- Стратегийн зорилго 5:** Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах
- Стратегийн зорилго 6:** Танхимын засаглал, менежементийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх

1. Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх стратегийн зорилгыг хангах хүрээнд

- 1.1 Бизнесийн төлөөллийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагуудтай бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх
- 1.2 Төрийн яам агентлагуудтай бизнесийг дэмжих чиглэлд хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажлын хэсэг, хороод, зөвлөлд бизнес эрхлэгчдийн болон танхимын оролцоог хангах
- 1.3 Төрийн болон бизнесийн төлөөллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичгүүдийг байгуулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих, үр дүн гаргах
- 1.4 Бодлогын өмгөөллийн чиглэлээр бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах гол механизм болох танхимын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжлэг үзүүлэх
- 1.5 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагууд, төрийн ба төрийн бус байгууллагууд болон төсөл хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх
- 1.6 Авлига ба бизнесийн зарчмууд, хүүхдийн эрх ба бизнесийн зарчмуудыг нийгэм ба бизнес эрхлэгчдийн дунд түгээн дэлгэрүүлэх, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах
- 1.7 Тогтвортой хөгжлийн зорилт, Ногоон хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг бизнес эрхлэгчдэд түгээх, энэ чиглэлээр төр болон хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах
- 1.8 Бизнес, эдийн засагтай холбоотой гарч буй аливаа хууль, тогтоол, бодлого шийдвэрүүдэд хувийн хэвшлийнхний санал бодлыг тусгуулах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийг хөгжүүлэх

2 Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах, бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах стратегийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд

- 2.1 Засгийн газар, УИХ-аар хэлэлцэгдэх хууль болон бодлогын баримт бичгүүдийн төсөлд бизнес эрхлэгчдийн саналыг тусгуулах талаар идэвх санаачлагатай ажиллах
- 2.2 Бизнесийн хууль эрх зүйн ба бодлогын өмгөөллийн чиглэлээр хэлэлцүүлэг, арга хэмжээг тогтмол үр дүнтэй зохион байгуулах
- 2.3 Танхимын бодлогын өмгөөллийн үйл ажиллагааг бизнес эрхлэгчид болон яамд, агентлагууд, мэргэжлийн холбоодод тогтмол мэдээлэх, сурталчлах
- 2.4 Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар холбогдох талууд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах

- 2.5 Гадаад худалдаа түүний дотор хөрш орнуудтай хийж байгаа худалдаанд учирч байгаа асуудлуудыг судлан шийдвэрлүүлэх талаар холбогдох талуудтай хамтран ажиллах
- 2.6 Гадаад худалдааг хөнгөвчлөх “Цахим нэг цонх”-ны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах
- 2.7 Оюуны өмчийн тухай хууль ба эрх зүйн баримт бичгүүдийг сайжруулах талаар санал боловсруулан хүргүүлэх
- 2.8 Гишүүд, бизнес эрхлэгчдийг нэн шаардлагатай хууль эрх зүйн мэдээллээр тогтмол хангах, зөвлөгөө өгөх тогтолцоог хөгжүүлэх, эргэх холбоотой ажиллах

3 Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах стратегийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд

- 3.1 Монгол улсын гадаад худалдааны түншлэгч орнууд болон бусад орнуудтай бизнес, хөрөнгө оруулалт, түншлэлийн платформыг хөгжүүлэх
- 3.2 Бизнес эрхлэгчдэд МҮХАҮТ-ын гишүүнчлэл ба үйл ажиллагааны талаар тогтмол сурталчлах, гишүүдийн тоог нэмэгдүүлэх
- 3.3 Гишүүд ба бизнес эрхлэгчдэд шаардлагатай гадаад, дотоод уулзалт, үзэсгэлэн яармаг, сургалт болон бусад арга хэмжээг тогтмол зохион байгуулах, мэдээллийг тогтмол хүргэх
- 3.4 Олон улсын болон хөрш орнуудад зохион байгуулагдах үзэсгэлэн яармаг бусад арга хэмжээнд гишүүд бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах
- 3.5 Шилдэг аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах арга аргачлалуудыг шинэчлэн боловсруулах, шалгаруулалтын арга хэмжээнүүдийг шинэлэг, үр дүнтэй байдлаар зохион байгуулах
- 3.6 Компанийн засаглал, нийгмийн хариуцлага, менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- 3.7 Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст зураасан кодны стандарт, техникийн үзүүлэлт, хэрэглээний талаар тогтмол зөвлөгөө өгөх, зураасан кодны хэрэглээг нэмэгдүүлэх
- 3.8 Импортын барааны тоо чанарт хийх экспертизийн үйлчилгээг олон улсын стандартын түвшинд үзүүлэх
- 3.9 Жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын зах зээлд сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх
- 3.10 Бизнес эрхлэгчид болон гишүүн байгууллагуудын чадавхийг сайжруулах чиглэлээр бизнесийн ба мэргэжлийн сургалтуудыг чанартай, хүртээмжтэй явуулах
- 3.11 Оюуны өмчийн итгэмжлэхийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах, оюуны өмчийн эрхийг хамгаалах талаар мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд явуулах
- 3.12 Ногоон хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг бизнес эрхлэгчдэд таниулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн сургалт, сурталчилгааны арга хэмжээг авч хэрэгжүүлэх

3.13 Арбитр, эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлэх, хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх, байгууллага, иргэдэд үзүүлэх эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээг өргөжүүлэх

3.14 Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад чиглэсэн танхимын үйлчилгээг өргөжүүлэх, тэдэнд шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгааг цаг алдалгүй хүргэх

4. Бизнесийн бүх талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх стратегийн зорилгын хүрээнд

4.1 Олон улсын болон бүс нутгийн худалдааг дэмжих байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, донор байгууллагуудын төсөл хөтөлбөрт хамрагдах замаар танхимын гадаад хамтын ажиллагааг улам бүр хөгжүүлэх

4.2 Сургалт судалгааны чиглэлээр их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудтай идэвхтэй, үр дүнтэй хамтран ажиллах чиглэлээр санамж бичиг байгуулах, хэрэгжилтийг хангах, тодорхой үр дүнгүүдийг гаргах

4.3 Салбар танхимуудаар дамжуулан хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчдэд танхимын үйлчилгээг хүргэх, тэднийг арга хэмжээнд хамруулах, өргөн хүрээний мэдлэг мэдээллээр хангах

4.4 Салбар танхимыг хөгжүүлэх стратегийг тодорхойлж хэрэгжүүлэх, тэдгээрийг Европын сэргээн босголт хөгжлийн банкны төсөлд хамруулах замаар чадавхийг нь бэхжүүлэх

4.5 Монгол улсад байгаа гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөллийн байгууллага, нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх

4.6 "Дэлхийн ЭКСПО" болон олон улсын томоохон арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахад оролцох

4.7 Монгол улс АТА Карнейн конвенцийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

4.8 МҮХАҮТ, ГХАҮТХ-ны хамтын ажиллагааны төслийн хүрээнд нэмүү өртгийн сүлжээг өргөжүүлэх, бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5 Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах стратегийн зорилгыг хангах хүрээнд

5.1 Бизнесийн орчны талаар тогтмол явуулдаг судалгаануудыг чанартай явуулж, холбогдох талуудад түгээхБизнесийн орчны судалгааны нэр төрлийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан судалгаануудыг явуулах

5.2 Бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг эдийн засаг, бизнесийн холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр хангах үйл ажиллагааг өргөжүүлэх

5.3 Танхимаас эрхлэн гаргадаг бизнесийн боловсрол ном, гарын авлагыг түгээх, хүртээмжийг сайжруулах, "Нэг цэгийн төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх

5.4 Танхимаас үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, аж үйлдвэрийн салбаруудын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй, тогтмол түгээх

5.5 Бүтээгдэхүүний гадаад ба дотоодын зах зээлийн судалгааг бизнес эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан явуулах, түүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

6. Танхимын засаглал, менежементийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх стратегийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд

6.1 Танхимын удирдах зөвлөл, тэргүүлэгчдийн хурлын тогтмол үйл ажиллагааг хангах, гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах, эргэх холбоог бэхжүүлэх

6.2 ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэх

6.3 Байгууллагын дотоод үйл ажиллагааны автоматжуулалт болон гишүүдийн мэдээлэл, бүртгэл, хяналтын системийг үр дүнтэй нэвтрүүлэх, ашиглах

6.4 Экспертизийн үйлчилгээнд ISO17020 Хөндлөнгийн хяналтын олон улсын стандартыг үр дүнтэй нэвтрүүлэх

6.5 Хүний нөөцийн Green ERP системийг танхимд үр дүнтэй нэвтрүүлэх, ашиглах

6.6 Танхимын маркетингийн бодлогыг сайжруулах

6.7 Хүний нөөцийн мэдлэг ур чадварын шаардлагыг тогтоож, сургалтын хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

6.8 Харилцаа холбоо, техник технологи, нөөцийн сайжруулалтыг хийж Виртуаль танхим болох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

6.9 Хүний нөөцийн мэдлэг ур чадварын шаардлагыг тогтоож, сургалтын хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх